

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Дараах ойлголтоос аль нь нийгмийн давхраажилтын боолын хэв маягт хамаарах вэ?

/1 оноо/

- A. Албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурладаг.
- B. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай байдаг.
- C. Гол төлөв Азийн улс орнуудын давхраажилтын уламжлалт хэв маяг.
- D. Эдийн баялгаар ялгаатай бөгөөд хувийн байр сууриа өөрчлөх боломжтой.

2. Дараах жишээнүүдийн аль нь бурангуй үзэл гэсэн ойлголтыг бүрэн илэрхийлж байна вэ?

/1 оноо/

- A. Өндөр албан тушаалтай хүмүүс илүү их эрх мэдэл, нөөц бололцоотой байхад, үйлчилгээний салбарын ажилчид харьцангуй бага орлого, боломжтой байдаг.
- B. Нэгэн компанийн удирдлага шинэ ажилтан авахдаа ижил боловсрол, туршлагатай хоёр хүний дундаас зөвхөн эрэгтэй хүн сонгож, эмэгтэйг нь “эмэгтэй хүн энэ ажлыг хийхэд хэцүү” гэж үзэн хасах.
- C. Хотын захирагч замын шинэчлэл хийх шийдвэр гаргахад тухайн бүсийн оршин суугчид түүний шийдвэрийг дагаж, замын хөдөлгөөнд түр хугацаагаар өөрчлөлт оруулж буйг хүлээн зөвшөөрөн мөрддөг.
- D. Хотын оршин суугчид хөдөөгийн хүмүүсийг боловсролгүй, хоцрогдсон гэж үзэх, харин хөдөөгийн хүмүүс хотынхныг ихэмсэг, амьдралын ухаангүй гэж үзэх хандлага.

3. Янки хотын нийгмийн давхраажилтыг судалсан Ллойд Уорнерийн судалгааны гол онцлог юу байсан бэ?

/1 оноо/

- A. Судалгааны үр үнд капиталист, менежер, ажилчин, жижиг хөрөнгөтөн гэсэн дөрвөн ангийг тодорхойлсон нь судалгааны гол онцлог юм.
- B. Бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ, хүндлэлээр давхраажилтын хэмжих загвар боловсруулсан нь судалгааны гол онцлог юм.
- C. Ангийн ялгааг өмчөөс гадна орлого, эрхэлж буй ажил мэргэжил гэсэн эдийн засгийн бусад хүчин зүйлсийг чухалчилж үзсэн нь судалгааны гол онцлог юм.
- D. Давхраажилтын судалгаанд намын ялгарлын асуудлыг судлаж, намын ялгарал нь нийгмийн бүлгүүдийн нэр хүндийн ялгаралтай холбоотой гэж үзсэн нь судалгааны гол онцлог юм.

4. Дараах эрдэмтдийг үзэл баримтлалтай нь зөв тохируулна уу.

/2 оноо/

а) Т.Парсонс б) Э.Дюркгейм в) Дэвис, Мур	1	Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд илүү өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг.
	2	Нийгмийн зөрчил нь зөвхөн ангийн ялгаанаас гадна, шашин, үзэл суртал, итгэл үнэмшил зэргээс ч хамаардаг, төгсгөлгүй шинжтэй, зөвхөн хэлбэрт нь өөрчлөлт гардаг.
	3	Нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж, зэрэглэгдэж байдаг. Тэгэхээр бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршдог.
	4	Ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаанд хүргэдэг. Энэ нь ангийн зөрчилд хүргэх ба ангийн зөрчил нь нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болдог.
	5	Нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж үздэг.

A. а4, в5, с1

B. а3, в5, с1

C. а5, в3, с1

D. а4, в5, с2

5. Дараах хүснэгтэд байгаа нийгмийн хэв маягуудыг ажиглаад аль нийгмийн хэв маягийн хэд дүгээр баганад алдаа байгааг тодорхойлно уу.

/3 оноо/

Нийгмийн хэв маяг	1-р багана	2-р багана	3-р багана
Ан агнуурын нийгэм	Австралийн уугуул иргэд ийм төрлийн нийгмийн байгуулал бүхий байсаар байна.	Нүүдэллэн амьдардаг нийгэм бөгөөд улс төрийн бүтэц үгүй	Чулуу, сүх, жад, хутга зэрэг энгийн зэвсэг ашигладаг.
Цэцэрлэг аж ахуйн нийгэм	НТӨ 4000 он тэртээ үүсэж Ази, Европ даяар тархсан	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр худалдаа арилжаа үүссэн	Ураг төрлийн холбоонд суурилсан олон төрлийн овгуудаас тогтох нийгэм
Газар тариалангийн нийгэм	Өрх гэр бүлд суурилсан эдийн засгийн харилцаа оршин байсан.	Ураг төрлийн холбоонд тулгуурладаг.	Төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болсон.
Аж үйлдвэржсэн нийгэм	Их Британи дахь аж үйлдвэржилтийн нөлөөгөөр XVIII зууны сүүлчээр үүссэн	Төвлөрөн суурьшсан хотын маш олон хүн амын хэрэгцээг хангах болсон.	Төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоонд суурилсан

- A. Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 2-р багана
Газар тариалангийн нийгмийн 2-р багана
- B. Ан агнуурын нийгмийн 1-р багана
Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана
- C. Газар тариалангийн нийгмийн 2-р багана
Аж үйлдвэржсэн нийгмийн 1-р багана
- D. Газар тариалангийн нийгмийн 3-р багана
Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 2-р багана

6. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж тодорхой хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд хамаарах хүрээг олно уу. /1 оноо/

- A. Дизайн, дүрслэх урлаг (хувцас загвар, дизайн, гар урлал, уран зураг)
B. Соёлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилгыг дэвшүүлэх
C. Соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
D. Соёлын салбарт хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

7. Соёлын эрх чөлөөний суурь зарчмуудыг дараах өгөгдлөөс олоорой. /1 оноо/

a) Соёлын эрх чөлөөний суурь зарчим	1	Амьдралын хэв маягийг үгүйсгэх
	2	Бүх хүмүүсийн соёлын үнэт зүйлийг хүндэтгэх
	3	Хувь хүний сонголт хийх бололцоог өргөжүүлэх
	4	Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
	5	Өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх

- A. 1, 4 B. 3, 5 C. 2, 5 D. 2, 3

8. “Харь соёлд дасан зохицох үе шат”-уудыг зөв ойлголттой нь харгалзуулна уу. /2 оноо/

a) C цэг b) D цэг c) F цэг	1	Эргэн тойрныхоо хүмүүсийг ойлгож эхэлж, харилцаа тогтоох.
	2	Шинэ орчинд бүрэн дасна.
	3	Бага багаар орчиндоо дасаж, шинэ зүйлийг хүлээн авч чаддаг болно.
	4	Найз нөхөдгүй, нийгмээс тусгаарлагдсан мэдрэмж төрнө.

- A. a2b3c4 B. a4b3c2 C. a3b1c2 D. a3b2c4

9. Дараах өгөгдлүүдээс Дж.Кэмпбеллийн эрх чөлөөний тухай үзэл баримтлалыг олоорой. /2 оноо/

- Хэнд ч байгалиас заяасан засаглах эрх, өөрөөр хэлбэл, хэнд ч бусдыгаа захирах төрөлх эрх гэж байхгүй.
- Эрх чөлөө бол хувь хүний амьдралын эрхэм зорилго, хувь хүний өөрийгөө нээх боломж мөн.
- Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй, айж хугарсан нэгэн болгодог.
- Эрх чөлөөгөө оллоо гэхэд юу хийхээ мэддэг байх нь хамгийн чухал, эрх чөлөөтэй байх эсэх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална.
- Хуулийн зорилго нь хүнийг эрхийг устгах буюу хавчин хясах явдал биш, харин түүнийг хамгаалж өргөжүүлэх явдал мөн.

- A. 1, 5 B. 3, 5 C. 2, 4 D. 2, 3

10. Татвар гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Хуулийн дагуу тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж.
 - B. Төрийн зохих байгууллагаас ААН, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тухайн бүрд нь авч төсөвт оруулдаг мөнгөн хөрөнгө.
 - C. Төрийн өмчийг ашиглуулсны төлөө иргэн, ААН, байгууллагаас авч төсөвт оруулдаг мөнгөн хөрөнгө.
 - D. Төрийн зохих байгууллагаас иргэнд үйлчилгээ үзүүлсний төлөө тухайн бүрд нь авч төсөвт оруулдаг мөнгөн хөрөнгө.

11. Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөн
 - B. Гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авах үйл явц
 - C. Тухайн орны үнэт цаасыг гадаадын иргэд, ААН-үүд худалдан авах үйл явц
 - D. Улс орнуудын хооронд бүтээгдэхүүн солилцох явцад үүсэж байгаа харилцаа

12. Дараах мэдээллийг уншаад, өгөгдсөн томъёоны дагуу тооцоолоорой. /2 оноо/
- Монгол улсын эдийн засаг 2023 онд 42 тэрбум байсан бол, 2024 онд 45 тэрбум болсон гэж үзвэл 2024 онд МУ-ын эдийн засаг хэрхэн өөрчлөгдсөн бэ?

$$\text{ЗЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

- A. 6.7% өссөн B. 6.7% буурсан C. 7.14% өссөн D. 7.14% буурсан

13. Хүснэгт дэх мэдээллээс Ф.Хайекын үзэл баримтлал болон түүний тухай мэдээллийг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй	Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй
2-р хэсэг	Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн 1974 онд Нобелийн шагнал олгосон.	Эх орныхоо өмнө байгуулсан гавьяаг үнэлэн “Лорд” зэрэг олгожээ.

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
B. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

14. Дараах өгөгдлүүдээс аль нь эзэмших эрхийг илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Тус баялгийг худалдах, арилжих зэргийг шийдвэрлэх боломжийг хэлнэ.
 - B. Тухайн баялгийн үр шимийг хүртэх боломжийг хэлнэ.
 - C. Тус баялгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах боломжийг хэлнэ.
 - D. Тус баялгийг бүрэн хараа хяналтдаа байлгах боломжийг хэлнэ.

15. Эрх зүйд захирагдах ёсны дагуу орчин цагийн үндсэн хуульд дараах зарчмыг удирдлага болгодог. Үүнд хамаарахгүй зарчмыг олно уу. /1 оноо/
- A. Төрийн эрх мэдлийг хуваарилах
 - B. Хүнлэг энэрэнгүй байдлыг бий болгох
 - C. Үндсэн хуулийг хянах тогтолцоог бүрдүүлэх
 - D. Нам, төрийг дээдэлж захирагдах

16. Хүснэгт дэх захиргааны акттай холбоотой ойлголтуудыг ажиглаад 1, 2 хэсгийг харьцуулаад, аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Захиргааны актыг илрэх хэлбэрийн хувьд аман, бичгийн, техникийн, үйл хөдлөл- хөдөлгөөний гэж ангилдаг.	Захиргааны актад формаль, материаллаг шаардлага тавигддаг.
2-р хэсэг	Захиргааны шийдвэр гэж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр юм.	Дээд шатны байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй.

- A. 1-р хэсгийн А B. 1-р хэсгийн Б C. 2-р хэсгийн А D. 2-р хэсгийн Б

17. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /3 оноо/

a) 1945 он	1	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
b) 1946 он	2	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
c) 1948 он	3	Нэгдсэн үндэсний байгууллага
d) 1966 он	4	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
e) 1996 он	5	“Magna charta” буюу “Эрх чөлөөний харти” хэмээх баримт бичиг
	6	Хүний эрхийн дээд комиссарын газар

- A. a3b1c4d2e5
B. a3b1c4d6e2
C. a3b6c4d1e2
D. a3b6c4d2e1

18. Д.Истоны улс төрийн системийн ойлголтуудын нэг болох “Оролцооны дэмжлэг” гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Сонгууль эсвэл санал асуулгад оролцож, тухайн нам, нэр дэвшигчийг дэмжиж буйгаа илэрхийлэх
B. Улс төрийн систем, түүнийг хүрээлэн байгаа экологи, соёл зэрэг янз бүрийн тулгалтууд
C. Иргэдийн нийгэмд оролцох, хууль тогтоомжийг дагаж мөрдөх, төрийн үйл ажиллагаанд оролцох
D. Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэн үзэх

19. Хэм хэмжээ зохицуулалтын дэд системд тохирох өгөгдлийг сонгоно уу? /2 оноо/

Хэм хэмжээ зохицуулалтын дэд систем	1	Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох
	2	Улс төрийн нам, сонирхлын бүлгээр дамжин улс төрийн амьдралд оролцох
	3	Төр, нам, сонирхлын бүлэг зэрэгтэй хамгийн түрүүнд холбогддог.
	4	Төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах үүрэгтэй.
	5	Зан заншлын, хууль зүйн хэм хэмжээ нь улс төрийн харилцан нөлөөлөл, үйлдлийг бэхжүүлэхэд чиглэдэг

- A. 1, 5 B. 2, 5 C. 3, 5 D. 4, 5

20. Нийгэмд эдийн засаг, нийгмийн байр суурь болон эрх ашиг нь ижил төстэй хүмүүсийн бүлгүүдийн санаа бодлыг зохион байгуулах, төрийн шийдвэр гаргахад тэдний эрх ашгийг илэрхийлэх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Агрегаци B. Артикуляци C. Интеграци D. Интервенц

21. “Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагыг хамруулан үздэг” гэдэг нь аль ойлголтод хамаарах вэ? /1 оноо/

- A. Олон улсын харилцаанд оролцох үүрэг
B. Олон улсын харилцааны улс оролцогч
C. Олон улсын харилцааны улс бус оролцогч
D. Олон улсын харилцаанд оролцох нөлөө

22. Олон улсын байгууллага нь хязгаарлагдмал хүрээнд, зөвхөн өөрийн үйл ажиллагааны зорилготой холбоотой асуудлаар эрх зүйн чадамж эдэлдэг. Тэгвэл дараах ойлголтуудаас аль нь хамаарагдахгүй вэ? /1 оноо/

- A. Зөвхөн өөрсдийн дүрмийн хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээдэг.
B. Олон улсын байгууллага шүүхээс зөвхөн зөвлөмж хүсэх эрхтэй.
C. Давж заалдах шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эрх зүйн акттай
D. Зөвхөн өөрсдийн эрхэлдэг ажлын тодорхой асуудлаар хэлэлцээр байгуулна.

23. Олон улсын байгууллагыг үйл ажиллагааны цар хүрээний ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А - /Глобал түвшин/	Б - /Бүс нутгийн түвшин/
1-р хэсэг	UNDP	Аль Кайда бүлэглэл
2-р хэсэг	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага	АПЕК

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг - Б
B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг - А
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг - Б
D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг - А